



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/83

Булган сум

Мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг
сонгон шалгаруулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар 60.1.1 дэх хэсэг 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан "Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зарцуулах журам", Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны 25 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2024-2028 оны "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)
Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн Үйлдвэрлэл, үйлчилгээний
салбарын бодлого хариуцсан мэргэжилтэн)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Г.Нарангэрэл (Булган сумын Засаг даргын Тамгын
газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010142